

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2021 оны 01 дүгээр сарын мэдээ

2021.01.25

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр: ИТХ-ын төлөөлөгч нарыг монголын нутгийн удирдлагын холбооны сургалтанд 2022 оны 01 дүгээр 03-наас 3 хоногийн сургалтыг зохион байгууллаа.

2022.01.13 ны өдөр ИТХ-ын ажлын албанаас ардчилсан шинэ үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойд зориулсан “Үндсэн хууль- 30” жил “АХА” тэмцээн, “Гар бөмбөг”-ийн тэмцээнийг тус тус зохин байгууллаа.

ИТХ-ын төлөөлөгчдийн ээлжит хуралдааныг хуралдуулж малын албан татварын тоо, толгойн татварыг хуваарилж батлах болон бусад асуудлаар хэлэлцэж шийдвэрлэлээ.

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Тухайн сард дээд газраас 19 албан бичиг ирсний 10 нь хариутай, 8 –нь хугацаандаа, 2–нь хугацаа болоогүй байна.

Сумын 2021 оны үйл ажиллагааны тайланг 13 чиглэлээр нэгтгэн аймгийн ХШҮДАХэлтэст хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Сумын засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/01 тоот захирамжаар цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг 2022 оны 01 дүгээр сарын 10 өдрөөс 01 дүгээр сарын 21 өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсан.

Сумын Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн А/03 тоот захирамжаар тус сумын 2 дугаар багийн нутаг “Бага ганган” хэмээх газарт өвөлжиж буй малчин Г.Ганбатын үхэрт малын гоц халдварт Шүлхий өвчин бүртгэгдэж шинжилгээгээр батлагдсан тул Дэлгэр багт 2022 оны 01 дүгээр сарын 14-ны өдрөөс 28 хоногийн хугацаатай тус газарт хэсэгчилсэн хорио цээрийн дэглэм тогтоогоод байна.

Сумын засаг даргын 2022 оны 01 дүгээр 19-ны өдрийн А/04 дугаар захирамжаар Коронавируст халдвар /Ковид -19/ цар тахлын тохиолдол тасралтгүй нэмэгдэж буйтай холбогдуулан түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдлээс хамгаалах, тэмцэх хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 20-ны өдөр хүртэл төрийн байгууллага хуулийн этгээд бүх төрлийн баяр ёслол сар шинийн битүүлэг нэгдсэн золголт, тэмдэглэлт ой олон нийтийг хамарсан урлаг спортын арга хэмжээ зохион байгуулахыг хориглосон шийдвэр гарч хэрэгжилтэнд цагдаагийн тасгаас хяналт тавьж ажиллаж байна.

Сумын Засаг дарга төсөвт байгууллагын албан хаагчидтай уулзалт хийж, 2021 онд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, 2022 онд хийхээр төлөвлөгдөж буй ажил, арга хэмжээг танилцуулан албан хаагчдад тулгамдаж буй асуудлын талаар санал бодлыг солилцлоо.

Хоёр: Төсөв санхүүгийн чиглэлээр:

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, авлигын эсрэг хуулийн тухай болон ХАСХОМэдүүлгийг хэрхэн гаргах талаар төсөвт байгууллагын дарга эрхлэгч нарт мэдээлэл аргачлал зөвлөмжийг өгч гарын авлага тараан ажиллаа.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар мэдээллийг цахимаар иргэдэд тогтмол хүргэж байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Бүрэн дунд сургууль: Сургуулийн захирал 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр 12 дугаар ангийн багш нартай уулзан Элсэлтийн ерөнхий шалгалтын ирц, явц, давтлага зэрэгтэй танлцан цаашид анхаарч ажиллах зөвлөмж, зөвлөгөө, чиглэлийг өглөө.

Сурагчдын хоцрогдлыг нөхөх, мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор мэргэжлийн багш нарын хичээлийн давтлага 01 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн явагдаж байна.

01 дүгээр сарын 04-05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх арга зүй, аргачлалыг таниулах” сэдэвт цахим сургалтад бага ангийн багш, Химийн багш, Дүрслэх урлаг, дизайн технологийн багш нар хамрагдсан.

Соёл: Монгол улсын ардчилсан шинэ үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойд зориулан сумын ИТХ-тай хамтран “Үндсэн хуулиа хэн сайн мэдэх вэ” АХА тэмцээн, үдшийн цэнгүүн, Дуучин Мөнх-Ундралын “Хөдөөгийн баясгалан” тоглолтыг хүлээн авч халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгууллаа.

Аймгийн аварга малчдад шагнал гардуулах ёслолын ажиллагаанд Хөгжмийн багш Ц.Амарбаатар оролцож урлаг соёлын явуулын үйлчилгээ үзүүлээ.

Номын сан нь ариутгал халдваргүйтгэлийн дэглэмийг баримтлан уншигчдад гэрээр ном олгон ажиллаж байна.

Байгууллагын 2021 оны ажлын статистик тайлан мэдээ санхүүгийн тайлан зэргийг цэгцлэн гаргаж холбогдох дээд байгууллагуудад хуулийн хугацаанд нь хүргүүллээ.

Цэцэрлэг: “Монгол бичиг”, “Угийн бичиг хөтлөх” арга зүй чиглэлээрхи сургалтыг ЕБС-ийн МХУЗ-ын багштай хамтран зохион байгуулж нийт 40 багш ажилчдыг хамрууллаа.

Багш нар цахимд шилжсэнтэй холбоотой хүүхдүүдтэй холбогдож хаана байгаа байршилыг тогтоож утас болон цахимаар байнга холбогдож дасгал даалгаврыг өгч ажиллаж байна.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчин: Агаар бохирдуулагчийн эх үүсвэрийн нэгдсэн тооллого явуулах ажлын хэсгийг 2022 оны 01 сарын 20-ны өдрийн А/07 тоот захирамжаар томилон ажиллаж сумын хэмжээнд нэгдсэн тооллогыг хугацаанд нь явуулж тайлан мэдээг зохих газарт хүргүүлэн ажилласан.

Ерөнхийлөгчийн тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах ажлын хэсгийг 2022 оны 01 сарын 20-ны өдрийн А/08 тоот захирамжаар томилон ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Аймаг, сумын аварга малчдыг шалгаруулж материалыг аймгийн ХХААГ-т явуулснаар Дөхөм багийн малчин Ч.Ганжигүүр, Г.Алтангэрэл, Дэлгэр багийн малчин Д.Ганзориг нар аймгийн аварга малчин өрхөөр шалгарсан.

Сумын засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн ” Сумын сайн “малчин, сумын алдарт уяач, сумын 9-н алдартнаа шалгаруулсан.

2021 оны малчин, мал бүхий иргэдийн 840 өрхийн “Ноосны мөнгөн урамшууллын материалын программ шинэчлэгдсэнийг засаж өөр программд шивж оруулсан.

Мал эмнэлэгийн чиглэлээр: 2022 оны 01 дүгээр сарын 10-нд Дэлгэр багийн Бага ганганд өвөлжиж буй Г.Ганбатын хотноос 1 үхрийн гоц халдварт өвчний дуудлага ирсний дагуу Аймгийн мал эмнэлэгийн газар, Сумын удирдлагуудад танилцуулж 2022 оны 01 сарын 10-ны өдрийн Сумын засаг даргын А/02 тоот хязгаарлалтын дэглэм тогтоох тухай захирамж гарган ажилласан.

Аймгийн мал эмнэлэгийн газрын лабораториас ажлын хэсэг ажиллаж, эдийн шинжилгээ авч малын гоц халдварт шүлхий өвчин 22-439 тоот бүртгэлийн дээжээр батлагдан 2022 оны 01 дүгээр сарын 14-ний Сумын засаг даргын А/03 тоот хорио цээр тогтоох тухай захирамж гарган ажлын хэсэг гарч ажиллаж байна. Голомтын бүсэд өвчилсөн 1 тугалан бяруунд ариутгал халдваргүйтгэл, үзлэг, тандалт өдөр бүр хийж мэдээлэл өгч байна.

Мөн шүлхий тандалт, зээрийн тандалтын ажлын хэсэг ирж ажиллав. Аймгийн мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Мал эмнэлэгийн газраас хамтарсан ажлын хэсэг ирж сумын авч хэрэгжүүлж буй ажилд зөвлөмж зөвлөгөө өгч ажиллаа.

Аймгийн мал эмнэлэгийн газраас 5 л шүлхий өвчний вакцин татан авч өвчлөл гарсан Дэлгэр багийн голомт, сэжигтэй бүс, хамгаалалтын бүсийн өрх айлын үхрийн тарилгыг хийхээр 3 ажлын хэсэг гарч 207 үхрийг дархлаажуулалтад хамруулаад байна.

Нэгтгэсэн: ХЭЗХ-мэргэжилтэн

Ж.Долгорсүрэн